



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№195 /405/

2022.10.31

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ УЛС ТУУХАЙ ӨРГӨЛТИЙН ДЭЛХИЙН АНХНЫ ХОШОЙ АВАРГАТАЙ БОЛЛОО



Бүгд Найрамдах Энэтхэг Улсад зохион байгуулагдаж байгаа Туухай өргөлтийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагч, дэд ахлагч Э.Буджав 68 килограммын жинд түлхэлттэй өргөлт болон огцом өргөлтөөр тус бүр алтан медаль хүртэж, эх орныхоо төрийн дууллыг хоёр өдөр дараалан эгшиглүүлэв.

Дөнгөж сая тэрээр хошой алтан медалиа гардан авч, тэмцээн зохион байгуулагч орон болон дэлхийн орнуудын

тамирчид онцгойлон баяр хүргэсэн байна. Түүний тэргүүлсэн түлхэлттэй өргөлтөд хүрэл медалийг Узбекистаны тамирчин, мөнгөн медалийг Польш Улсын тамирчин, огцом өргөлтөд хүрэл медалийг БНЭУ-ын тамирчин, мөнгөн медалийг ОХУ-ын тамирчин тус тус эзэлсэн юм.

Дэлхийн хошой аварга, дэд ахлагч Э.Буджав Үндэсний Батлан хамгаалахын Их сургуулийн Ерөнхий цэргийн ангид 2017 онд суралцаж байгаад ОХУ-ын

Кострома хотод Цацраг, хими, биологийн зэвсгээс хамгаалах цэргийн академид хоёр дах жилдээ суралцаж байна.

Тэр бээр 2018 онд Зэвсэгт хүчний Туухай өргөлтийн аварга шалгаруулах тэмцээнээс хос хүрэл медаль, мөн тэмцээнээс 2021 онд хос мөнгөн медаль хүртсэн цэрэгжлийн спортын шилдэг тамирчны нэг юм. Мөн ОХУ-д суралцаж байхдаа туухай өргөлтийн спортоор тууштай хичээллэсний үр дүнд

олон амжилтын эзэн болсон бөгөөд 2022 онд Туухай өргөлтийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс хос мөнгөн медаль, олон улсын "Цагаан шөнө" тэмцээнээс алтан медаль тус тус хүртэв.

Монгол Улсад түлхэлттэй болон огцом өргөлтөөр дэлхийн анхны хошой аваргаар Зэвсэгт хүчний тамирчин, дэд ахлагч Э.Буджав ийнхүү тодорч чадлаа. Тэрээр эх орондоо ирэх сарын 04-ний өдөр ирнэ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 0	☁️ -12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,412	3,420
EUR 🇪🇺	3,415	3,430
CNY 🇨🇳	467.50	473
RUB 🇷🇺	52.80	53.20
JPY 🇯🇵	23.20	23.50
KRW 🇰🇷	2.45	2.48

ЗУРХАЙ



2022.10.31 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 7

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.35-17.37

Барилдлага:

Идэр

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олодох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

БИДНИЙ НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ 383 НАС ХҮРЛЭЭ

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 383 жилийн ой "Нийслэлийн өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын төрийн далбаа, Нийслэлийн далбаа, Хан-Уул дүүргийн далбааг мандуулах ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Нүүдэлч удмын их төвлөрөл Алтан тэвшийн хөндийд суурьших хүртлээ 20-иод удаа нүүдэллэж 1778 онд Туулын хөндийд төвхнөсөн байдаг. Монголчууд 1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Цагаан нуур буюу Ширээт нуур гэх газар улсын шарын шашны тэргүүнээр өндөр гэгээн Занабазарыг өргөмжлөхдөө түүнд зориулан орд өргөөг байгуулсан нь өнөөгийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үүсэл болсон аж. Өргөө нь тухайн үедээ Монголын шарын шашин, Халх Монголын улс төрийн төв, гадаад, дотоодын худалдааны чухал зангилаа голомт байв. Мөн энэ үеэс Өргөө нь хот болон дэвжин хөгжиж

эхэлсэн бөгөөд Ардын хувьсгал ялсны дараа 1924 оны 10-р сарын 29-нд улсын нийслэл гэдгийг давтан хуульчилж, хотын нэрийг Улаанбаатар болгон өөрчилсөн талаар товч мэдээллийг бие бүрэлдэхүүнд өгсөн юм

Хошууч Ө.НАРАНТУЯА



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 635,472,864

Эдгэрсэн

Нийт: 614,615,307

Нас барсан

Нийт: 6,593,723

Цаг үе, үйл явдал

ТАНГАРАГ ӨРГӨХ ХҮРТЭЛХ ӨДРҮҮД МААНЬ ЗАВГУЙ ӨНГӨРӨХ БОЛОЛТОЙ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 013 ДУГААР АНГИ

2022 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн шинэ дайчдыг цэргийн албанд дасгаж, цэргийн анхан шатны мэдлэг олгох, цэргийн дүрмээр тогтоосон хэм хэмжээг мөрдүүлж албан үүрэгт нь сургах, тэднийг бие бялдар сэтгэл зүйн хувьд бэлтгэх зорилгын хүрээнд ХЦАХ-ын дунд сэтгэл зүйн хангалтын ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.

Шинэ дайчдыг төлөөлж байлдагч Н.Эрдэнэсүрэн хугацаат цэргийн албанд татагдан ирсэн сэтгэгдлээ хуваалцсан юм. Тэрээр Этүгэн их сургуулийн хоёрдугаар курсийн окутан бөгөөд цэргийн албанд мордохоор сэтгэл шулуудан иржээ.

"Тэнцээд маш их баярласан. Зэвсэгт хүчний 013 дугаар анги гэж бодохоор шууд л Тусгай салаа кино бодогдож байлаа. Эхний өдрөөс эхлээд цагийн хоолондоо дасах, өглөө эрт сэрэх, жагсаалд хөл гараа олох гээд амаргүй зүйлс нэлээдгүй байсан. Гэнэт л алба хаах шийдвэр гаргасан. Хурдан богино хугацаанд шийдсэн болоод ч тэр үү маш их зүйлс бодогдож байсан ч энд ирээд ард амьдралд төсөөлж байснаас тэс өөр болохыг мэдэрч байна. Сурах зүйлс, дасах зүйлс ч нэлээдгүй байна. Юутай ч эх орондоо тангараг өргөх хүртэлх өдрүүд маань завгүй өнгөрөх бололтой" хэмээсэн юм.

Ахлах ахлагч Н.Ууганцэцэг



ШИНЭ ДАЙЧДАД СПОРТ, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖЛЫГ ТАСРАЛТГҮЙ ЯВУУЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 167 дугаар анги 2022 оны хоёрдугаар ээлжээр Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цэргийн жинхэнэ албанд татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдаа цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг явуулж байна.

Уг үйл ажиллагааны хүрээнд өнгөрсөн амралтын өдрүүдэд шинэ дайчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бүлгээр ажиллах чадварыг нэмэгдүүлэх, нэгнээ таньж нөхөрлөх, хамтач уур амьсгал бүрдүүлэх зорилготой олс таталтын тэмцээнийг зохион байгуулахад тэргүүн байрт дэслэгч Б.Алтайхүү салааны захирагчтай II мотобуудлагын ротын II салаа, дэд байрт дэслэгч Б.Амин-Эрдэнэ салааны захирагчтай I мотобуудлагын ротын III салааны баг тамирчид шалгарч хамт олноо манлайллаа.

Дэслэгч Б.Батзаяа

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 116 ДУГААР СУРГУУЛИЙН СУРАГЧИД МҮЗЕЙД ЗОЧИЛОО



Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн сурагчид Монгол цэргийн музейд зочлон Монгол цэргийн түүхэн замналаар аялсан нэгэн өдрийг өнгөрүүлээ.

Монгол цэргийн музей нь 2014 онд ХАХНХЯ-наас "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй музей"-гээр нэрлэгдэж үүнээс хойш хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан үзүүлэг сурталчилгаа, үзүүлэгчийн заалыг шинэчлэн дэглэж тухайн иргэдийн онцлог тохирсон боловсрол, олон нийтийн ажлыг тасралтгүй зохион байгуулсаар ирсэн аж.

“ЖИШИГ ТОХИЖИЛТТОЙ ХАШАА” БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 110 ДУГААР АНГИ

Зэвсэгт хүчний БИЦУГ-ын хамт олон “ЖИШИГ ТОХИЖИЛТТОЙ ХАШАА” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн Дашням, Балжинням давхацсан билигт сайн өдөр, Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад

анги хамт олноо манлайлан оролцсон Барилга Угсралт, Засварын ротын салааны ахлагч-тасгийн захирагч ахлах ахлагч Б.Хүрэлчулууны хувийн эзэмшлийн хашааг иж бүрэн тохижуулж ар гэрт нь хүлээлгэн өглөө.

Ахлагч Б.ОДГЭРЭЛ

АНГИЙН УДИРДЛАГА ШИНЭ ДАЙЧИДТАЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



хүргэсэн юм.

Мөн энэ үеэр ангийн захирагч хурандаа М.Болдбаатар “98 жилийн бахархам амжилт, бахдам гавьяатай энэхүү ангид хугацаат цэргийн албаа хаахаар ирсэн дайчдаа итгэл хүлээлгэж Төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаа, цэргийн дээд шатны байгууллагын харуул хамгаалалтын эрхэм үүргээ мадаггүй гүйцэтгэнэ гэдэгт итгэл төгс байгаагаа” илэрхийллээ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИ

2022 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг ангийн захирагч, удирдлагын бүрэлдэхүүн хүлээн авч уулзалт зохион байгууллаа.

Уг үйл ажиллагааны хүрээнд ажиллагааны удирдлагын тасгийн дарга хошууч Э.Ундрах ангийн түүхэн замнал, үүрэг зориулалт, онцлог, ололт амжилтын талаарх мэдээллийг шинэ дайчдад

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №13

Зарим онцлог зурлагын нийлэмж /үргэлжлэл/

2. Нумны дараа орсон нум, завжийг доор үзүүлсэн байдлаар, зай гаргалгүй нийлүүлж бичдэг.
3. Дараалан орсон хоёр гээг, хоёр эврийн хооронд зай буюу урт нуруу авч бичдэг.
4. Ма, Ла үсгүүд дараалан орвол Ла-гийн эврийг Ма-гийн гэзгийн гадуур гаргаж бичдэг.

Дармалаар:

Бичмэлээр:

